

АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ЖАГСААЛТ

	Илэрсэн асуудлууд	Мөнгөн дүн	Хэрэгжүүлсэн арга хэмжээ буюу тайлбар
1	<p>Засгийн газрын 2007 оны 349 тоот тогтоолын “2.”албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашиныг ажлын хоногт дунджаар 70 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай” заалтыг зөрчин 1,517 км буюу 370,200.00 төгрөгөөр шатахууны зардлыг хэтрүүлсэн.</p>	370 200	<p>Тус газрын дарга нь Нийслэлийн Онцгой комиссын гишүүний үүрэгт ажлын дагуу хотын доторхи зарим үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагууд, 3,4 дүгээр цахилгаан станцын ажил үйлчилгээ, Нийслэл хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд хяналт тавьж ажилладаг. Үүний улмаас дээрхи 1,517 км буюу 370.2 мянган төгрөгийн шатахууны зардлын өр төлбөр үүсгэгдсэн. Цаашид холбогдох хууль тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Шатахуун хэтрүүлсэн өр төлбөр болох 370,200.00 төгрөгийг тогтоосон хугацаанд барагдуулсан.</p>
2	<p>Нийслэлийн тээврийн газар нь 2014 оны албан хэрэгцээнд 10 автомашин хэрэглэж байгаа нь “НЗДТГазар, Засаг даргын дэргэдэх агентлагийн дотоод албан хэрэгцээнд хэрэглэх суудлын автомашины төрөл, тоог тогтоох тухай “ Төрийн өмчийн хорооны 2008 оны 64 дүгээр тогтоолоор Нийслэлийн тээврийн газар нь албан хэрэгцээнд нь суудлын 3 автомашин хэрэглэхээр заасныг зөрчсөн байна. Зөвшөөрөлгүй 7 автомашины шатахууны зардал 13,495.7 мянга, жолоочийн цалинд 50,993.3 мянга, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 5,609.2 мянга, сэлбэг хэрэгслийн зардалд 5,480.1 мянга, автомашины элэгдлийн зардалд 10,983.3 мянган төгрөг, нийт 86,561.6 мянган төгрөгийн зардал гарсан байна.</p>	86 561 600	<p>Нийслэлийн Засаг Даргын 2011 оны 838 дугаар захирамжаар KIA RIO маркын 5 автомашиныг хотын доторхи хяналт тавих шаардлагатай тул 2013 онд Нийслэлийн Өмчийн Харилцааны газарт 2/1335 тоот албан бичиг явуулсны хариуд 2013 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 7/5737 тоотойр ” KIA RIO маркын 5 автомашин нь 2011 оны жилийн эцсийн тайлан балансад тусгагдаж, 2012 оны Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг, тооллогоор бүртгэлтэй хөрөнгийн жагсаалтанд орж баталгаажсан болно” гэж мэдэгдсэн.</p> <p>Нийслэлийн Засаг Даргын 2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн А/988 дугаар захирамжаар Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай захирамжласны дагуу 61-68 уне улсын дугаартай, 52 сая төгрөгийн үнэтэй авто машиныг Нийслэлийн өмчид шинээр бүртгэх тээврийн хэрэгслийн жагсаалтаар авсан болно.</p>

3	<p>Бараа материалын тайланд 27,000.00 мянган төгрөгийн шатахууны нэр төрөл, нэгж үнэ, тоо ширхэгээр бүртгээгүй нь Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад Нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Сангийн сайдын 2000 оны тушаал “ Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ын 2.3”Өөрийн хариуцлаганд ирж байгаа мөнгөн хөрөнгө, бараа материал, түүхий эд, тоног төхөөрөмж, эд хогшил, үнэт цаас, үр тариа зэрэг зүйлийг хүлээж авахдаа түүний тоо, үнэ, чанар, бүрэн бүтэн эсэх болон зохих баримт бичгүүдтэй тохирч байгаа эсэхийг шалгана” заалтыг зөрчсөн байна</p>	27 000 000	<p>Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад Нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Сангийн сайдын 2000 оны тушаал “ Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ын 2.3”Өөрийн хариуцлаганд ирж байгаа мөнгөн хөрөнгө, бараа материал, түүхий эд, тоног төхөөрөмж, эд хогшил, үнэт цаас, үр тариа зэрэг зүйлийг хүлээж авахдаа түүний тоо, үнэ, чанар, бүрэн бүтэн эсэх болон зохих баримт бичгүүдтэй тохирч байгаа эсэхийг шалгана” заалтын дагуу 2015 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдлөг болгон ажиллаж байна.</p>
4	<p>Тооцооны дансаар дамжуулаагүй 2,159,189.9 мянган төгрөгийг зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, “19.1.4. “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баримтжуулах “ зөрчсөн байна.</p>	2 159 189 900	<p>2014 оны жилийн эцсийн тайлангаар 2,159,189,9 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэсэн алдааг тухайн онд залруулга хийн бүртгэж, цаашид холбогдох хууль, тогтоомж, заавар журмын дагуу мөрдлөг болгон ажиллаж байна.</p>
	Дүн:	2 273 121 700	